



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 04 дугаар сарын 11

№ 11/63 УАГ-НАГ/2017/01-НА

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын үр дүнд нийцлийн аудит хийх явцад 670,328,136.00 /Зургаан зуун далан сая гурван зуун хорин найман мянга нэг зуун гучин зургаан/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. 2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр аймгийн төвд хэрэгжүүлэх ажлын жагсаалтад иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлж болохгүй "Төсөл хөтөлбөр арга хэмжээ" /"Иргэний эрх зүйн боловсрол", "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", "Архигүй Дундговь", "Аялал жуулчлалыг хөгжүүлэх", "Барилгын материалын чанарт тавих лабораторын хяналтыг өргөжүүлэх", "Төр - Улаан загалмайн хамтын ажиллагаа", "Бизнес эрхлэгчдийг дэмжих", "И-офисс" хөтөлбөр", "Сурагчдын Лиг" спортын арга хэмжээ", "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт", Сургууль төгсөгчдөд зориулсан "Мэргэжлээ зөв сонгох" сургалт, "Соёлын биет бус өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх сургагч багш нар бэлтгэх" төсөл, "Үзмэр сэргээн засварлах лаборатори" төсөл, Төрийн байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааг ТББ-аар үнэлүүлэх, "Оюун ухааны олимпиад", "Төрийн албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх" төсөл, "Эрүүл-Дундговь" төсөл, Монголын тогооч нарын холбооны удирдах ажилтны "Дундговь-2017" улсын зөвлөгөөн/ -ний зардалд 150,385,536.00 төгрөг зарцуулахаар баталсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно/, 60.3.1.-д /орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ/, 60.4.-т /Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй./, 60.3.6-д /орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/, 63 дугаар зүйлийн 63.1.-д /Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна/, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай" журмын 4 дүгээр зүйлийн 4.4-т /Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх болон урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй/, 6.6-д /Аймаг

нийслэлийн Засаг даргад иргэд, олон нийтээс хамгийн их санал, ажлын хэсгийн дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд олон нийтэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон иргэний танхимаар дамжуулан 11 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж хэлэлцүүлэг зохион байгуулна./, 6.7.-д /Аймаг нийслэлийн ИТХ-нь Аймаг нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг төсөл тус бүрээр хэлэлцэн төсвийн төсөлд тусган "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын сум/ дүүргийн ИТХ-ын хуралдааны тогтоол /загвар маягт/-ын 3 дугаар хавсралтын дагуу батална./, 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай" журмын 6 дугаар зүйлийн 6.3.3.-т /хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх/ заасныг,

2. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын зарим хэсгийг аймгаас баталж, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр, аймгийн чиг үүрэгт хамаарах хөрөнгө оруулалт /"Сүм хөх бүрд цогцолборын дэд бүтэц цахилгаан дамжуулах шугам дэд өртөөний барилга байгууламж, ногоон байгууламж", "Цэнгэлдэх хүрээлэн Мандалговь цэцэрлэгт хүрээлэн байгуулах", "Жуулчны баазуудын хоорондох тэмдэг, тэмдэглэгээ"/-ын ажлыг санхүүжүүлж 519,942,600.00 төгрөгийн зориулалт бус зарцуулалт хийлгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.6-д /тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр санхүүжүүлнэ/, 60 дугаар зүйлийн 60.1.-д /Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна./, 14.1.-т /Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна:/, 14.1.17.-д /аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн./, 14.2.-т /Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:/, 14.2.4.-т /өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах/, 63 дугаар зүйл./Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах/, 63.4.-т /Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална./, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай" журмын 5 дугаар зүйлийн 5.10-т /Сум, дүүргийн ИТХ-нь сум дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг төсөл тус бүрээр хэлэлцэн төсвийн төсөлд тусган "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын сум/ дүүргийн ИТХ-ын хуралдааны тогтоол /загвар маягт/-ын 3 дугаар хавсралтын дагуу батална./ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг

хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.5-д /Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага, нөхцлийг хангаагүй/, 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангаагүй, "Төсөл хөтөлбөр арга хэмжээ" нэрээр зориулалтын бус зардалд зарцуулахаар төлөвлөсөн ажлуудыг жагсаалтаас хасч тодотгон, шаардлага хангасан хөрөнгө оруулалтад зарцуулах,


2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуваарилах, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний төслийг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд жилийн төсвийн хязгаарт багтаан боловсруулж хэрэгжүүлэх

3. Цаашид орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуулиар хориглосон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарцуулахгүй, хууль журмыг мөрдөж ажиллах.

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 05 дугаар сарын 25-ны дотор аймгийн Аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-очир/ нарт даалгав.

ӨГСӨН¹:

АХЛАХ ШИНЖЭЭЧ



Д.ИХБАЯР

¹Акт, албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.